

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 01 сарын 06-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

*Тогтоолд өөрчлөлт оруулах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дахь хэсгүүд, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Нээлттэй өрийн хэрэгсэл гаргах тухай” 22/07 тоот тогтоолын Бондын нийт үнийн дүн, бондыг эргүүлэн худалдан авах үнэ, нөхцөл, бондын барьцааны хэсэгт өөрчлөлт оруулан, хавсралт 1-ээр баталгаажуулсугай.
2. Энэхүү тогтоолын 1-д заасны дагуу Бонд гаргахтай холбоотойгоор “Бонд эргүүлэн худалдан авах нөхцөл”-ыг хавсралт 2-оор баталсугай.
3. Бондын нөхцөл өөрчлөгдсөнтэй холбогдуулан “Бондын гэрээ”-нд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ байгуулах, холбогдох үйл ажиллагааг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА





## БОНДЫН НӨХЦӨЛ

Бондын арилжаа	Монголын Хөрөнгийн Биржээр олон нийтэд нээлттэй хүрээнд
Бондын төрөл	Энгийн хүүтэй бонд
Бондын нийт үнийн дүн	8'500'000'000.0 /Найман тэрбум таван зуун сая/ төгрөг
Нэгж бондын нэрлэсэн үнэ	100'000.0 /Нэг зуун мянга/ төгрөг
Бондын нийт тоо, ширхэг	85'000.0 /Наян таван мянга/ ширхэг
Бондын хугацаа	18 сар
Бондын жилийн хүүгийн түвшин	19.2 /Арван ес аравны хоёр/ хувь
Хүү төлөгдөх давтамж	Улирал тутамд
Хүүгийн төлбөр тооцоолох аргачлал	Жилийн хүүг 365 хоногоор тооцох ба бондын хоёрдогч арилжаа эхэлсэн өдрөөс хойш 3 сарын дараах мөн өдөр төлнө. Хүү төлөх өдөр амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлөх бөгөөд энэ тохиолдолд амралтын өдрүүдэд хүүг нэмж тооцохгүй ба дараагийн хүүг мөн өдрөөс эхлэн тооцно
Бондыг хугацаанаас өмнө буцаан худалдах Бонд эзэмшигчийн эрх	Бонд эзэмшигч нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 сарын дараа Бондыг үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах эрхтэй
Бондын эргэн төлөлт хийгдэх	Бондын хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 18 дахь сарын мөн өдөр төлнө. Хэрэв амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлнө
Бондыг эргүүлэн худалдан авах үнэ	Бондын үндсэн төлбөр (нэрлэсэн үнээр) болон хуримтлагдсан хүүгийн төлбөрийн нийлбэр дүн байна
Бондын барьцаа	Бондын эргэн төлөлтийн баталгааг тус компанийн толгой компани “Монголын финтек групп” ХК-ийн эзэмшиж буй 111,785,000 (нэг зуун арван нэгэн сая долоон зуун наян таван мянга) ширхэг буюу 16.8 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий энгийн хувьцаагаар бондын хүүгийн болон үндсэн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангана
Бондын батлан даалт	“Монголын финтек групп” ХК нь Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгох 8,500,000,000 (Найман тэрбум таван зуун сая) төгрөгийн үнийн дүн бүхий Бондын үндсэн болон хүүгийн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор батлан даалт гаргана
Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалт	Зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ
Бондын хадгалалт, төлбөр тооцоо	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв



## Бонд эргүүлэн худалдан авах нөхцөл

Бондыг хугацаанаас өмнө буцаан худалдах Бонд эзэмшигчийн эрх	Компани нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 сарын дараа Бонд эзэмшигчийн хүсэлтийн дагуу Бондыг зах зээлийн үнээр эргүүлэн худалдан авна
Бондыг эргүүлэн худалдан авах үнэ	Бондын үндсэн төлбөр болон хуримтлагдсан хүүгийн төлбөрийн нийлбэр дүн байна
Бондыг эргүүлэн худалдан авах хугацаа	Компани нь бонд эзэмшигч хүсэлт гаргасан тохиолдолд Бондын үнийн дүнгээс хамааран дараах хугацаанд бондыг эргүүлэн худалдан авна. <ul style="list-style-type: none"><li>- 50,000,001 (тавин сая нэг) төгрөгөөс дээш үнийн дүнтэй бол Бонд эзэмшигч мэдэгдэл ирүүлснээс хойш ажлын 10 хоногийн дараа;</li><li>- 50,000,000 (тавин сая) хүртэл төгрөгийн үнийн дүнтэй бол мэдэгдэл ирүүлсэн тухайн өдөр;</li></ul>
Бондын татвар	Бонд гаргагч нь Бонд эзэмшигчийн бондтой холбоотойгоор олсон хүүгийн орлогын үнийн дүнгээс татварт ногдох 5 хувийг суутган шилжүүлж, Бонд эзэмшигчийн нэрийн өмнөөс төсөвт шилжүүлэн тайлагнана
Арилжааны шимтгэл	Бондыг худалдах, худалдан авах арилжааны шимтгэлийг талууд тус бүрдээ хариуцна